



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 301 дүгээр тушаал, Үндэсний статистикийн хорооны Хөдөлмөрийн дотоод журмын 7 дугаар бүлгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Баянхонгор, Булган аймгуудад Өрхийн нийгэм, эдийн засаг, Ажиллах хүчний судалгааны мэдээлэл цуглуулалтын ажлын явцыг шалгах ажлаар Хүн ам, нийгмийн статистикийн газрын дарга А.Амарбалыг 2019 оны 07 дугаар сарын 16-ны өдрөөс 07 дугаар сарын 26-ны өдрүүдэд, ахлах статистикч С.Болормаа, Э.Гантуяа, статистикч Л.Ундрал нарыг 07 дугаар сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 07-ны өдрүүдэд, статистикч Д.Даваажаргалыг 07 дугаар сарын 16-ны өдрөөс 07 дугаар сарын 22-ны өдрүүдэд, статистикч Б.Уламбадрахыг 07 дугаар сарын 18-ны өдрөөс 07 дугаар сарын 24-ний өдрүүдэд томилон ажиллуулсугай.

2.Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Баянхонгор аймгуудад ажиллах томилолтын зардлыг холбогдох төсвөөс гаргахыг Тамгын газрын Санхүүгийн хэлтэс /Д.Батсүх/-т зөвшөөрсүгэй.

3.Томилолтын ажлын тайланг ирсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан Тамгын газарт илтгэх хуудсаар танилцуулахыг Хүн ам, нийгмийн статистикийн газрын ажилтан /С.Болормаа, Э.Гантуяа, Л.Ундрал, Д.Даваажаргал, Б.Уламбадрах/ нарт даалгасугай.

ДАРГА



Ч.ЦЭВЭГДОРЖ